

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2020 оны жилийн эцсийн тайлан, бодлогын газруудаас гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 17 зорилтын 72 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 17 зорилтын 72 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Хяналтанд авагдсан 72 арга хэмжээний 42 арга хэмжээг яам толгойлон, 30 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба нийт 72 арга хэмжээний биелэлт 50.3%-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 90.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 66 арга хэмжээний биелэлт 48.4 хувь,
- Засаглалын бодлогын хүрээний 3 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 70.0

- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 60.0 хувь, хэрэгжүүлсэн нийт 72 арга хэмжээний биелэлтийг 50.3 хувьтай дүгнэлээ.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО
/2020 оны жилийн эцсийн байдлаар/**

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
			90	70	50	30	0	
Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	1	1	1	0	0	0	0	90.0
Хоёр. Эдийн засгийн бодлого	11	66	10	13	14	23	6	48.4
Дөрөв. Засаглалын бодлого	3	3	1	1	1	0	0	70.0
Тав. Ногоон хөгжлийн бодлого	2	2	1	0	0	1	0	60.0
Дүн	17	72	13	14	15	24	6	50.3

Хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй буюу 0 хувийн биелэлттэй 6 арга хэмжээ байна.

- 3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ зорилтын 3.2.1.6.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах.
- 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ зорилтын 2. Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.
- 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ зорилтын 6."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.
- 3.6.3. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ зорилтын 2.1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.
- 3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ зорилтын 2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.
- 3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ зорилтын 4. Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

Дөрөв. Дүгнэлт.

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2020 оны жилийн эцсийн байдлаар **50.3** хувьтай дүгнэснээс 13 арга хэмжээ үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 14 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 15 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувь, 24 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 30 хувь, 6 арга хэмжээ хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй буюу 0 хувийн хэрэгжилттэй байна.

2. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлтийг гаргуулаагүй байна.

Тав. Санал, зөвлөмж.

1. Төрийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлэгчээр тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг толгойлон хэрэгжүүлэх байгууллагаас гаргуулан авах, хэрэгжилт хариуцсан нэгжүүдтэй хамтран ажиллах албан хаагчдыг сонгож үүрэгжүүлэх,

2. Ямар нэгэн арга хэмжээ зохион байгуулаагүй арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах, зорилтот түвшинд хүргэх, ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалт, ажлын уялдааг сайжруулах,

3. Салбарын хэтийн болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах шаардлагатай байна.

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2020 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.


Хянасан:
ХШҮДАГ-ын дарга



Ц.Одхүү

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан:

ХШҮДАГ-ын ахлах шинжээч



Х.Цэнд-Аюуш

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын 2020 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан,
2. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын 2020 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ц.Одхүү хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын 2020 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг холбогдох журмаар тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИН БИЧИЙН
ДАРГА  Г. НАНДИНЖАРГАЛ

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2020 оны жилийн эцсийн байдлаар

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ эх үүсвэр /сая.төг/	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
						Он		
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО								
1.1.6. Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.	1.	1. Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	УУХҮЯ-ны ГТБГ, УУБГ, ГХЯам			Ковид-19 цар тахлын улмаас манай улсын эрдэс бүтээгдэхүүний экспорт буурч тасалдах нөхцөл үүссэнтэй холбоотойгоор Засгийн газраас шат дараатай арга хэмжээ авсаны нэг нь Монгол, Хятадын "Ногоон гарц" журам бөгөөд энэхүү түр журмын хүрээнд нүүрс тээврийн жолооч нарыг Хятадын талд хонуулах арга хэмжээг авч эхэлсний дүнд 2020 оны 9 дүгээр сараас өдөрт дунджаар 1800 орчим тээврийн хэрэгсэл хил нэвтэрч эхэлсэн. Ингэснээр 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2.1 тэрбум ам.долларын 28.6 сая тн чулуун нүүрс экспортлоод байна. Засгийн газрын 2020.09.16-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлээр Дорнод аймгийн нутаг дэвсгэрт орших газрын тосны ашиглалтын Тосон-Уул-ХИХ, Тамсаг-ХХИ талбайнуудад БХГ-ний дагуу явагдаж буй газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаанд оролцох инженер техникийн ажилтан болон төслийн үйл ажиллагаанд шаардлагатай тусгай зориулалтын машин техник, тоног төхөөрөмж, бараа материалыг	90

							БНХАУ-аас Баянхошуу-Өвдөг, Бичигт-Зүүнхатавч боомтоор нэвтрүүлэх үйл ажиллагааг Монгол, Хятадын хилийн боомтын "Ногоон гарц"-ыг хэрэгжүүлэх түр журмын хүрээнд зохион байгуулахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг холбогдох талуудтай хамтран зохион байгуулж ажиллах тухай 2020.09.25-ны өдрийн 01/2349 тоот албан бичгийг Дорнод, Сүхбаатар аймгийн Засаг дарга нар болон АМГТГ-т явуулаад байна. Баянхошуу болон Бичигт боомтоор явагдаж буй газрын тосны экспортын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж дээрх боомтуудаар явагдаж буй газрын тосны экспортын тээвэрийг 48 автоцистернээр гүйцэтгэж байсныг нэмэгдүүлэн, өдөрт 70-74 автоцистерн болгон нэмэгдүүлээд байна.	
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ:	2.	1. Оюу Толгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулна.	2020 - 2024	"Оюу Толгой" ХХК УУХҮЯ, "Эрдэнэс оюу Толгой" ХХК	913.7 сая.\$ буюу 2,599,732.0 2008-2020 он хүртэлх далд уурхайн санхүүжилт /Гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээлээр/	Далд уурхайн нэвтрэлт 43,222 экв.метр. Газрын гадарга руу гарах туузан дамжуурга 14,981 экв.метр.	Далд уурхайн нэвтрэлт 48,173 экв.метр, 112 хувь Газрын гадарга руу гарах туузан дамжуурга 12,762 экв.метр, 85 хувь Инженерийн зураг төсөл 99.7 хувь Босоо ам 3, 4-ийн барилгын ажил 60.44 хувь Материал гаргах систем 64.9 хувийн хэрэгжилттэй ба 2020 онд төлөвлөсөн далд уурхайн бүтээн байгуулалт 95 хувьд хүрсэн.	90
	3.	2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой	2020 - 2024	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, УУХҮЯ	344,379.5 /Төрийн өмчит компанийн	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 30 хувь Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 18 хувь	70

	асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ.			санхүүжилтээ р/	нэвтрүүлэлт 52 хувьд. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 17 хувьд. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 15 хувьд. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 100 хувьд хүрнэ.	Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 15 хувь Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 80 хувьд тус тус хүрсэн.	
4.	2.1. Мөчлөгт урсгалт тээврийн технологи	2020 - 2021	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч "ЗВ ТЕС АУФБЕРЕЙТ UNGSSYST EME" GmbH компани, УУХҮЯ	60,200.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээ р/	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 52 хувьд хүрнэ.	ТЭЗҮ-ийн боловсруулалт 70 хувьд. Инженерингийн ажил 90 хувь Захиалсан бутлуурын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 24 хувь Захиалсан конвейерийн системийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 50 хувь Захиалсан тоног төхөөрөмжийн нийлүүлэлт 19 чингэлэг, удахгүй ирэх чингэлэг 26. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 30 хувьд хүрсэн.	70
5.	2.2. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр	2020	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ туслан гүйцэтгэгч "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК, УУХҮЯ	4,108.8 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээ р/	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 100 хувьд хүрнэ.	Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 100 хувь, үйлдвэрийн бүтээн байгуулалт 80 хувьд хүрсэн.	90

6.	2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл	2020 - 2023	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ туслан гүйцэтгэгч "Jiangxi Naipu mining machinery and new materials" Co.ltd, "FLSmidth Mongolia" ХХК, УУХҮЯ	235,233.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл хувьд хүрнэ 17	Баяжуулах үйлдвэрийн Өөрөө нунтаглах хэсгийн газар шорооны ажлын гүйцэтгэл 77.5 хувь Үйлдвэрлэлийн захиалсан үндсэн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 80 хувь Тоног төхөөрөмжийн суурийн ажил 53.6 хувь Баяжуулах үйлдвэрийн Нунтаглан баяжуулах хэсгийн инженерийн тооцоо, зургийн ажил 70 хувь Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, нийлүүлэлт 35 хувьд хүрч Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн 2020 оны гүйцэтгэл 100 хувийн хэрэгжилттэй байна.	90
7.	2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл	2020 - 2024	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, УУХҮЯ	44,837.7 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл хувьд хүрнэ. 15	Хүйтнээр хатуурах холимгоор хэв бэлтгэх хагас автомат шугамын гүйцэтгэл 100 хувь, Засвар, механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан ТЭЗҮ болон инженерийн зураг төслийг боловсруулах ажил 10 хувь, Засвар, механикийн заводын Цутгуурын цехийн элчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл шинэчлэлийн ажил 5 хувь Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэлийн 2020 оны гүйцэтгэл 100 хувийн хэрэгжилттэй байна.	90
8.	3. Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулна.	2021 - 2024	"Эрдэнэ цагаан суварга" ХХК, УУХҮЯ	3.0 сая.сая.\$ буюу 8,535.84 /Өөрийн хөрөнгөөр/	2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй.	ТЭЗҮ-ийн тодотголыг бэлтгэсэн. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт хэлэлцээрүүд хийгдэж байна.	30
9.	4. Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг,	2020 - 2024	"Багануур" ХК, "Шивээ овоо" ХК, "Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	44574.63 Гадаадын зээл тусламж /JBIC/	Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 51 хувьд хүргэнэ. Шивээ-Овоогийн	Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэл 51 хувь буюу 2020 оны гүйцэтгэл 100 хувьд. Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36 хувь буюу 2020 оны гүйцэтгэл 100 хувьд хүрсэн.	90

	зардлыг бууруулна.				нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36 хувьд хүргэнэ.		
10.	4.1. "Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэл	2020 - 2021	"Багануур" ХК, УУХҮЯ, "Эрдэнэс Монгол" ХХК	29786.91 Гадаадын зээл тусламж /JBIC/	Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 51 хувьд хүргэнэ.	7 м³ экскаватор 1 ш, 100 тн самосвол хөрс 6 ш, 60 тн самосвол нүүрс 3 ш, гинжит бульдозер 2 ш нийт 12 ш тоног төхөөрөмжийг шинэчлэн, үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэл 51 хувь буюу 2020 оны гүйцэтгэл 100 хувьд хүрсэн.	90
11.	4.2. Шивээ-овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн үлдэгдэл хөрөнгө оруулалт.	2020 - 2024	"Шивээ овоо" ХК, УУХҮЯ, "Эрдэнэс Монгол" ХХК	14787.72 Гадаадын зээл тусламж /JBIC/	Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36 хувьд хүргэнэ	7 м³ экскаватор 2ш, 60 тн самосвол нүүрс 5 ширхэгийг шинэчлэн Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36 хувь буюу 2020 оны гүйцэтгэл 100 хувьд хүрсэн.	90
12.	5. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ.	2020 - 2024	"Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	429.6 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Туршилт судалгааны ажил 50 хувьд. Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг 55 хувьд хүрнэ	Туршилт судалгааны ажил 30 хувь, Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг 60 хувь Дэд бүтэц, бэлтгэл ажлын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 0.6 хувьд хүрсэн.	50
13.	5.1. 3.2.1.5.1. Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалт.	2020 - 2021	"Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	346.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Туршилт судалгааны ажил 50 хувьд хүрнэ	Ордоос 30 тн дээж бэлтгэн, SGS Mongolia олон улсын лабораторид анхан шатны туршилтууд хийгдэж байна. Туршилт судалгааны ажил 30 хувьд хүрсэн.	50
14.	5.2. 3.2.1.5.1. Асгатын мөнгөний ордын зөвлөх	2020 - 2022	"Эрдэнэс Монгол" ХХК, УУХҮЯ	47.99 /Төрийн өмчит компанийн	Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг 55 хувьд хүрнэ	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгжийг сонгон шалгаруулж, нөөцийн категориог өнөөгийн нөөцийн ангилалд нийцүүлэх ажил боловсруулагдаж байна.	90

	үйлчилгээний хөрөнгө оруулалт.			санхүүжилтээр		Зөвлөх үйлчилгээний 2020 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 100 хувьд хүрсэн.	
15.	6. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2020 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	11,241.2 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй.	2020 оны төсөвт суулгасан 2 флит уулын техникийн худалдан авалтыг хийсэн. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэлтийн хөрөнгө оруулалт 4.5 хувьд хүрсэн.	30
16.	6.1. 3.2.1.6.1. Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт.	2020 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	11,241.2 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй.	2020 оны төсөвт суулгасан 2 флит уулын техникийн худалдан авалтыг хийсэн. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэлтийн хөрөнгө оруулалт 4.5 хувьд хүрсэн.	30
17.	6.2. 3.2.1.6.2. Конвейерийн системийн хөрөнгө оруулалт	2021 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	3,500.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй	ТЭЗҮ боловсруулах ажил 10 хувьд хүрсэн.	30
18.	6.3. 3.2.1.6.3. Нүүрс баяжуулах үйлдвэр	2021 - 2023	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	1,317.2 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй	Төслийн Монгол Улсын стандарт шаардлага хангасан ТЭЗҮ боловсруулах ажил дууссан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд шаардлагатай мэргэжлийн шинжээчдийн баг 2020 оны 11 дүгээр сарын 12-нд томилогдон ажиллаж байна. Шинжээчдийн багийн дүгнэлт гарсаны дараа ЭБМЗ-ийн хуралдаанд хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. ТЭЗҮ-ийг боловсруулах, батлуулах ажил 95 хувьд хүрсэн.	30

	19.	6.4. 3.2.1.6.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах.	2021 - 2022	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ		2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй	Хэрэгжилт 2021 оноос гарна.	0
	20.	6.5. 3.2.1.6.5. Усан хангамж шийдвэрлэх.	2021 - 2023	"Эрдэнэс-Тавантолгой" ХК, УУХҮЯ	417.76 /Төрийн өмчит компанийн санхүүжилтаар/	2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй	Загийн усны хоолойн гүний усны ордоос Тавантолгой уурхай хүртэл 70 км шугам хоолой татах трассыг баталгаажуулан захирамж гаргасан. Тус усан хангамжийн системийг цахилгаанаар хангах техникийн нөхцлийг ЭХЯ болон Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-аар гаргуулсан. Ус хангамжийн системийн зураг төсөл боловсруулах ажил дууссан. Баталгаажуулах гарын үсэг зурах, экспертизээр хянуулах шатанд хүлээгдэж байна. Зураг төсөл, холбогдох шийвэр гаргах ажлууд 90 хувьтай.	30
3.2.2. Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ:	21.	1. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана.	2021 - 2024	УУХҮЯ, "Эрдэнэс силвер ресурс" ХХК, "Эрдэнэс Монгол" ХХК	44.100.00 /өөрийн хөрөнгөөр/	2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй.	Эрдэнэс сильвер ресурс ХХК-ийн Дундговь аймгийн нутаг дахь Салхитын мөнгөний ордыг ил аргаар ашиглах уурхай 2020 оны гүйцэтгэлээр 209.3 мян.тн хүдэр олборлож, 105.9 мян.тн хүдэр баяжуулж, 1944.2 тн баяжмал үйлдвэрлэж, нийт 101.1 тэрбум төгрөгний борлуулалтын орлоготой ажилласан байна. Цаашид тус компанийн зүгээс Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах хүрээнд жилд 300 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийг барихаар бэлтгэл ажлыг хангаж байна.	50
	22.	2. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна.	2021 - 2024	УУХҮЯ, Монголросц ветмет ТӨҮГ	Төсөв тусгагдаагүй	2020 онд бүтээн байгуулалтын ажил төлөвлөгдөөгүй	Календарчилсан төлөвлөгөөний дагуу ТЭЗҮ-ийг АМГТГ-д хүргүүлж (2020-09-29), тус газраас томилогдсон шинжээчтэй гэрээ (2020-11-23) байгуулсан. Шинжээчийн дүгнэлтийн дагуу холбогдох засварыг хийсэн. ТЭЗҮ-ийн боловсруулалт 80 хувьтай.	30

3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	23.	1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47 хувийг хамруулна	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, УГА, Аж ахуй нэгжүүд	Улсын төсөв 8,512.1	Нутаг дэвсгэрийн 41%-ийг хамруулах	Тэрэм уул-50, Тээгийн гол-50, Сант-50, Баян-Индэр-50 төслүүдийн үр дүнг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн УУХҮС-ын 2020 оны А/35, А/39, А/149, А/150 дугаар тушаалаар хүлээн авсан. Дээрх 4 төслийг хэрэгжүүлснээр 12,370.21 кв.км талбай буюу 0.8%-ийг бүрхсэн ба нийт нутаг дэвсгэрийн 41.06%-ийг бүрэн бүрхээд байна. Дээрх 4 төслийн талбайн хэмжээнд ялгасан ашигт малтмалын хэтийн төлөвтэй бүхий 20 эрдсийн хуримтлалтай талбайг ялгасан. 2020 онд шинээр Овоот толгой-50, Улаангом-50, Уушгийн улаан-50, Торлог уул-50, Хар хайрхан-50, Их бэрх уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Их хараат уул-50, Үнэгт уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, нийт 12 төслийг шинээр хэрэгжүүлж эхэлсэн. Худгийн нуруу-50, Норовлин-50, Их Өлзийт-50, Цайлангийн нуруу-50, Галбын говь-50, Сүүжийн говь-50, Номгоны нуруу-50, Олон гол-50, Шүтээн улаан уул-50 төслүүдийн үр дүнг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	50
	24.	3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулна	2021-2023	УУХҮЯ-ны ГБГ, УГА, Аж ахуй нэгжүүд	Улсын төсөв 1,549.1	Нутаг дэвсгэрийн 14%-ийг хамруулах	Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К, L, M (N) хавтгайн хэмжээнд нэгтгэх төслийн 2020 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар батлуулж К хавтгайн суурин боловсруулалт, L хавтгайн суурин болон хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Мөн дээрх 2 төслийн 2020 оны хээрийн болон суурин боловсруулалтын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж УУХҮС-ын А/127, А/130 дугаар тушаалаар баталсан. Монгол орны М (N) хавтгайн хэмжээнд иж бүрдэл зургийг нэгтгэх ажлыг 2020 онд эхлүүлэхээр УУХҮС-ын А/254 дүгээр тушаалаар төлөвлөгөө, төсвийг баталсан. Судалгааны ажлын геологийн даалгаврыг УУХҮ-ийн дэд сайдын 2020 оны 2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр баталсан. Төслийн	50

						ажлыг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулж гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй гэрээг 6-р сарын 12-нд байгуулж ажлыг эхлүүлсэн. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг нутаг дэвсгэрийн 220,395 кв.км талбайд буюу 14%-д хийж дууссан. Тус төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажилласан.	
25.	4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулна	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, УГА, Аж ахуй нэгжүүд	Улсын төсөв 593.9	Нутаг дэвсгэрийн 63%-ийг хамруулах	Монгол орны баруун хэсэгт буюу 104,044.0 кв.км талбай /6.6%-г хамарсан агаарын геофизикийн 1:200000-ны масштабын 5 сувгийн судалгааны ажлыг 2020 онд хэрэгжүүлэхээр геологийн даалгаврыг боловсруулан УУХҮ-ийн дэд сайды 2020 оны 2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр, УУХҮС-ын 2019 оны А/254 дугаар тушаалаар төсөв, төлөвлөгөөг тус тус батлуулсан. Энэхүү Ховд-2020 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулж гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч байгууллага гэрээ болон ажлын даалгаварт заасны дагуу төлөвлөгөөт онд нийт 104,044.0 кв.км буюу 6.6% талбайгаас 53,062 кв.км буюу 51%-д судалгааг хийсэн. Өөрөөр хэлбэл нийт 58960 тууш км нислэг үйлдэхээс 30283 тууш км нислэгийг үйлдсэн байна. Ингэнээр нутаг дэвсгэрийн 63.4%-ийг судалгааны нислэгт хамруулж, завсрын суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна.	90
26.	5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулна	2021 - 2022	УУХҮЯ-ны ГБГ, УГА, Аж ахуй нэгжүүд	Улсын төсөв 1,427.9	Нутаг дэвсгэрийн 65%-ийг хамруулах	Монгол орны нутаг дэвсгэрийн 1,0 сая кв.км талбайг хамарсан 1:1000000-ны масштабын геохимийн зураглал хийх, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны ажлыг 2020 онд үргэлжлэн хэрэгжүүлэхээр УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар төсөв, төлөвлөгөөг батлуулж суурин боловсруулалт, хээрийн судалгааны ажлын бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Төлөвлөгөөт онд Монгол орны төв,	70

						зүүн хэсэгт буюу L-47, 48, 49, M-47, 48, 49 хавтгайд хээрийн судалгааны дээжлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд ингэснээр судалгааны талбайн 65%-д хээрийн судалгааг гүйцэтгэсэн.	
27.	6. Бүс нутаг болон хотуудын геозкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийнэ	2021-2024	УУХҮЯ-ны ГБГ, ҮГА, Аж ахуй нэгжүүд	Улсын төсөв 562.4	Төслийн ажлын үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	1. Эрдэнэт хотын геозкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2020 онд үргэлжлэн хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн суурин болон хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн УУХҮС-ын 2020 оны А/126 дугаар тушаалаар батлаж үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. 2. Дархан хотын геозкологи, гидрогеологийн судалгааны ажлыг 2020 онд хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар, ажлын даалгаврыг УУХҮ-ийн дэд сайдын 2020 оны 2-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр тус тус баталсан. Судалгааны ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг цахимаар зарлаж гүйцэтгэгч хуулийн этгээдийг шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг 2020 оны 6-р сарын 12-ны өдөр байгуулан ажлыг эхлүүлсэн. Дээрх 2 төслийн 2020 оны хээрийн судалгааны ажлын баримт материалыг цахимаар хүлээн авсан.	50
28.	7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ	2021-2024	УУХҮЯ-ны ГБГ, ҮГА, Аж ахуй нэгжүүд	Улсын төсөв 4,004.3	Төслийн ажлын үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ өгөх зорилго бүхий АМС-2017 судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн суурин болон хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн УУХҮС-ын 2020 оны А/125 дугаар тушаалаар батлаж үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнгийн тайланг 2021 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Монгол орны баруун хэсэгт тархсан хурдас чулуулгийн	30

						тулгуур зүсэлт, геологийн өвөрмөц, тогтоцыг судалж баримтжуулах ажлыг УУХҮС-ын эрдэм шинжилгээний ажилд зарцуулах төсвөөс санхүүжүүлэн 2021 оноос хэрэгжүүлэх саналыг холбогдох газарт хүргүүлсэн. Мөн 2021 оноос хэрэгжүүлж эхлэхээр Мезо-Кайнозой-2021, Монгол орны хагарлын зураг зохиох төслийн төлөвлөгөө, төсвийн хэмжээг тооцон холбогдох газарт хүргүүлсэн. Төслүүдийг 2021 оноос хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.		
	29.	8. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, ҮГА	Улсын төсөв 228.3	Төслийн ажлын үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКаЗУ-ын хамтарсан "Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" төслийн 4-р шатны ажлын 2020 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 2020 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын А/124 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 4-р шат буюу "Их Алтай"-н төслийн хэмжээнд Монголын тал Монгол Алтай нуруунд судалгааны ажлыг хэрэгжүүлж байгаа бөгөөд суурин боловсруулалтын ажлыг 2020 онд гүйцэтгэн, 2021 онд үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70
3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	30.	1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, ҮГА	Улсын төсөв 909.3	Төслийн ажлын үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Үндэсний геомэдээллийн санг Интрузив, эффузив чулуулгийн үнэмлэхүй насны мэдээллийг нэгтгэх, Давхарга зүй, палеонтологийн олдвор, горизонтын тулгуур зүсэлтийн мэдээллийг нэгтгэх, хээрийн баримт материал, үр дүнгийн тайлангийн мэдээллийг цахимаар хүлээх авах, сан бүрдүүлэх аргачлал, үлгэрчилсэн загвар боловсруулах, багажны хэмжилтийн утгыг нарийвчлан гаргах, бүх төрлийн масштабын геологийн зураг, давхаргын мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, нэгдсэн загварт оруулах зорилгоор	50

		үйлчилгээг хялбаршуулна					2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн Геомэдээлэл-2019 төслийн 2020 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2020 оны А/129 дүгээр тушаалаар баталж суурин боловсруулалтын ажлыг эхлүүлээд байна. 2021 онд төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
	31.	2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, УГА		5%	Геомэдээллийн сан хөтөлбөрийн хүрээнд бүх төрлийн геологийн судалгааны ажлын явцад авсан чулуун дээжийг цэгцлэх, мэдээллийн сан үүсгэх болон геологийн баримтын төв архивт хадгалагдаж байгаа анхдагч баримт бичгүүд, цаасан тайланг цахим архивт оруулах зорилгоор УУХҮС-ын 2021 оны төсвийн багцад батлагдсан санхүүжилтийн эх үүсвэрээр Цахим архив-1, Чулуун дээжийн сан-1 төслүүдийг хэрэгжүүлэхээр тооцоо, судалгааг хийн бэлтгэл ажлыг хангаж байна.	50
3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.	32.	1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, УГА	Улсын төсөв 577.6	Төслийн ажлын үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	1. Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлыг төлөвлөгөөт онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар төлөвлөгөө, төсвийг батлуулсан. Судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2020 оны А/143 дугаар тушаалаар батлуулан суурин болон хээрийн судалгааны ажлын бэлтгэл ажлыг эхлүүлсэн. Стратегийн ашигт малтмалын төрлүүдийг тектоник, металлогени болон бусад геологийн хүчин зүйлс, дэд бүтэц зэрэг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлүүдтэй хамтатган судалж, өнөөдрийн нөхцөлд стратегийн ашигт малтмал гэж авч үзэх төрлүүдийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн тодорхойлох, үнэлэлт, дүгнэлт өгөх, энэхүү судалгааны үр дүнд дэлхийн түүхий эдийн зах зээл дээр эрэлт ихтэй өндөр технологийн болон энергийн	70

							түүхий эдийг нарийвчлан судалж, Монгол Улсын экспортын чиг хандлагыг тодорхойлох суурь судалгааныг 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж үр дүнг хүлээн авна. 2. "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг хэрэглэх аргачилсан зөвлөмж"-ийг газрын ховор элемент, литий-цезийн төрлөөр боловсруулах ажлыг АМЕР-2 төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ГУУС-ийн харьяа Эрдэс баялгийн судалгаа, геомэдээллийн сургалтын төвөөр хийлгэж байна. 2021 оны 2-р дугаар улиралд багтаан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.	
33.	2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, УГА	Улсын төсөв 1,824.9	Төслийн ажлын үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	1.1. Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт орших 245.01 кв.км талбайд үнэт, холимог металлын чиглэлээр эрэл-үнэлгээний ажил (ЭҮ-1-2020)-ыг шинээр хэрэгжүүлэхээр төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн дэд сайдын 2020.02.14-ний өдрийн шийдвэрээр батлуулсан. Төслийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахимаар зохион байгуулж шалгарсан этгээдтэй гэрээ байгуулсан. Судалгааны ажлын 2020 оны хээрийн судалгааны ажлын анхдагч баримт материалыг хүлээн авсан. 1.2. "ТЗМ-Алт-2017" төслийн үр дүнгийн тайланг 2021 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 1.3. 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн "БӨМ-Алт-2019"-ын 2020 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2019 оны А/254 дүгээр тушаалаар батлуулсан. Төслийн 2020 оны суурин болон хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын А/125 дугаар тушаалаар батлуулж судалгааны ажлыг эхлүүлсэн. Хээрийн ажлын баримт материалыг хүлээн аваад байна. 2. "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг	70	

						хэрэглэх аргачилсан зөвлөмж"-ийг хөнгөн цагаан, бал чулуу, давс, карбонат чулуулаг, элс хайрга гэсэн төрлөөр боловсруулах ажлыг АМЕР-2 төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ГУУС-ийн харьяа Эрдэс баялгийн судалгаа, геомэдээллийн сургалтын төвөөр хийлгэж 2021 оны 2-р улиралд багтаан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Мөн молибден, цагаан тугалга, вольфрам, хар тугалга-цайр гэсэн төрлөөр боловсруулж дууссан бөгөөд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авах ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хийсэн ба 2021 оны 04 дүгээр сард багтаан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.	
34.	3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, УГА, АМГТГ	Хувийн хөрөнгө оруулалт	Сонгон шалгаруулалтаар олгосон хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо нэмэгдүүлсэн байх	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, холбогдох материалыг боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулсан. Дээрх тушаалыг батлуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу УУХҮСайдын тушаалын нөлөөллийн үнэлгээ, холбогдох материалыг бэлтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж эрх зүйн актын улсын бүртгэлд бүртгүүлсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай УУХҮСайдын 2020 оны 8 дугаар сарын А/204, А/215 дугаар тушаалыг батлуулсан. 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 6 багцаар 53 талбай зарласнаас 27 хайгуулын тусгай зөвшөөрөл олгоод байна. Сонгон шалгаруулалт СШ-46, СШ-47 дугаар багцууд УОК-оос гаргасан шийдвэрийн дагуу техникийн санал нээх явц хойшлогдсон. СШ-45-н техникийн саналыг үнэлэн санхүүгийн	70

							саналыг нээсэн. Шалгарсан аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрөл олгох шийдвэр хүлээгдэж байна. Улсын төсөвт 2020 оны жилийн эцсийн байдлаар 4.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.	
3.2.6. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.	35.	1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгоно.	2020 - 2022	УУХҮЯ-ны ГБГ, ҮГА, АМГТГ, Бусад яамд, Төрийн бус байгууллагууд	Төсөв тусгагдаагүй	2020 онд ажил төлөвлөгдөөгүй	Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батлуулсан ба тус хуулийн хүрээнд дээрх зорилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна.	30
	36.	2. Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлын хүрээнд яамны харьяанд аж ахуйн тооцоот газрыг бий болгоно.	2020 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, ҮГА, АМГТГ	Төсөв тусгагдаагүй	2020 онд ажил төлөвлөгдөөгүй	Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллага байгуулах талаар гадаад, дотоодын судалгааны ажил хийж байна.	30
	37.	3. Орон нутаг эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, ҮГА, АМГТГ	Төсөв тусгагдаагүй	2020 онд ажил төлөвлөгдөөгүй	Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн аймгуудын бүтэц батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд орон нутаг эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулах санал хүргүүлсэн.	30
	38.	4. Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам,	2021 - 2024	УУХҮЯ-ны ГБГ, ҮГА, АМГТГ, БШУЯ, ХНХЯ	Төсөв тусгагдаагүй	2020 онд ажил төлөвлөгдөөгүй	Судалгаа хийгдэж байна.	0

		байгууллагатай зохион байгуулна.						
3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ:	39.	1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ-ны ХҮБГ, "Кью эс си" ХХК, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Холбогдох яамдууд	1,641.2 Хувийн хөрөнгө оруулалт	Төслийн удирдлага, инженеринг, тоног төхөөрөмж захиалах	Одоо байгаа гангийн үйлдвэрт хаягдал төмөр боловсруулах төхөөрөмж /шредерын төхөөрөмж/ суурилуулах ажлыг эхлүүлсэн. Шинээр гангийн үйлдвэр байгуулах төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж байна. Уул уурхай хар төмөрлөгийн цогцолбор" байгуулах төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 1-р шатны ажлууд болох төмрийн хүдрийн ордуудаа эдийн засгийн эргэлтэнд оруулах, уул уурхайн үйлдвэрлэлийг дэд бүтцийн хамт байгуулах ажлуудыг амжилттай хэрэгжүүлэн төмрийн хүдрийн 2 уурхай нээж, уурхайнууд дээр хуурай соронзон баяжуулах үйлдвэрүүд, гангийн үйлдвэрийн дэргэд нойтон баяжуулах үйлдвэр зэргийг дэд бүтэц /төмөр зам, ачиж буулгах терминал, авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц г.м/-ийн хамт барьж байгуулсан. Төслийн 2-р шатанд шууд ангижруулсан төмрийн үйлдвэр, гангийн үйлвэрийг өтгөтгөх, шинэ гангийн үйлдвэр байгуулах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд: Дэлхийн банкны "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл"-ийн хүрээнд "Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн техник-эдийн засгийн үндэслэлийг Канад Улсын "Hatch" компани гүйцэтгэн 2017 онд, "Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ"-г Монгол Улсын "Экотон" ХХК болон "Ажид" ХХК, "Экосфер" ХХК-иуд гүйцэтгэж 2019 онд тус тус хүлээлгэн өгсөн. -Ган бөмбөлгийн цувих үйлдвэр барих талбайн инженер геологийн судалгаа -25000 тн/жил хүчин чадалтай ган бөмбөлгийн давтах аргын үйлдвэр	70

							<p>-6 кв-ын цахилгаан дамжуулах кабелийн шугам, 6 кв-ын хуваарилах байгууламж, 6/0.4 кв-ын 2x2500 кВА чадалтай дэд станцын барилга</p> <p>-Бэлдэц үйлдвэрлэх цех дэх 25 тн багтаамжтай шанаган зуухны тоног төхөөрөмж</p> <p>-Бэлдэц үйлдвэрлэх цехийн 6/0.4 кв-ын 1600 кВА дэд станц, үйлдвэрийн 110/22/6.6/6 кв-ын Төмөрлөг дэд станцыг 110/22 кв-ын 6.3 МВА дэд станцаар өргөтгөсөн өргөтгөл, 22кв-ын цахилгаан дамжуулах кабелийн шугам, барилга</p> <p>-Хаягдал төмрийг боловсруулах пресс хайчны тоног төхөөрөмжийн угсралт</p> <p>-Цахилгаан соронзон холигч, хэлбэлзүүлэгч ширээ, зэс талсжуулагч шинээр суурилуулах ажлыг 2019 оны 03 сард эхлүүлсэн бөгөөд туршилтын ажлыг хийж 04 сард ашиглалтад оруулсан. Төслийн хүрээнд дээрх бүтээн байгуулалтын ажилд нийтдээ 630.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдээд байна.</p> <p>УУХҮС-ын 2019.06.03-ны өдрийн А/136 дугаар тушаалаар байгуулагдсан "Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл хэрэгжүүлэх концессын гэрээ"-ний хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг нь төслийн явц 75 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн.</p>	
40.	2. Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2020 - 2022	УУХҮЯ-ны ХҮБГ, "Бэрэн групп" ХХК, Холбогдох яамдууд	0.0 Хувийн хөрөнгө оруулалт	Барилга, дэд бүтцийн ажлыг дуусгаж тоног төхөөрөмжийн худалдан авалт, угсралт, суурилуулалтын ажлыг хийнэ.	Ковид 19 цар тахал болон хөрөнгө оруулалтын саатлаас болж үйл ажиллагаа явагдаагүй.	0	
41.	3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна.	2020 - 2023	УУХҮЯ-ны ХҮБГ, "МДМУ" ХХК, Холбогдох яамдууд	4,600.0 Хувийн хөрөнгө оруулалт	Цутгуур болон дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмжийн угсралт	Цутгуурын болон дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн.	30	

42.	4. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	2020 - 2022	УУХҮЯ-ны ХҮБГ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Холбогдох яамдууд	2306	ТЭЗҮ, технологийн түвшний үнэлгээ, гидрогеологийн судалгаа	Паркийн техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, техник, технологийн үнэлгээ хийлгэх, паркийн геозкологи, гидрогеологийн судалгаа гүйцэтгэх ажлыг тайлант хугацаанд зохион байгуулсан. Мөн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гүйцэтгэх ажлыг зохион байгуулсан.	30
43.	5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	2020 - 2024	УУХҮЯ-ны ХҮБГ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ, Холбогдох яамдууд	3300	ТЭЗҮ-ийн тодотгол	Жилд 120,000 тн катодын зэс үйлдвэрлэх хүчин чадалтай зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг 2020 онд БНХАУ-ын ENFI компани боловсруулж дуусгасан. УУХҮЯ-ны ЭМБЗ-ийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	30
44.	6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна	2020 - 2022	УУХҮЯ-ны ХҮБГ, Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ, Холбогдох яамдууд	0	Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.	2016 онд боловсруулсан ТЭЗҮ-ийг 2021 онд шинэчлэн боловсруулах, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөсөн. 2021 оноос ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжинэ.	0
45.	7. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ-ны ХҮБГ, "Эрдэнэс Алт ресурс" ХХК, "Эрдэнэс Монгол" ХХК Монголбанк, АМГТГ	0	Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр барьж, байгуулна	Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийн хэрэгжүүлэх зорилгоор "Эрдэнэс монгол" ХХК-ийн ТУЗ-ийн "Охин компани байгуулах тухай" 2018 оны 6 дугаар тогтоолоор "Эрдэнэс монгол" ХХК-ийн харъяанд байгуулагдсан төрийн өмчит "Эрдэнэс Алт ресурс" ХХК төслийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2020 онд дараах ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд: - БОАЖЯ-ны Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хурлаар төслийн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсан;	50

						<ul style="list-style-type: none"> - Япон улсын хөрөнгө оруулалтын SBI групптэй төслийн хөрөнгө оруулалтын асуудлаар уулзалт, хэлэлцээр хийж, харилцан мэдээлэл солилцож байна; - Үйлдвэрийн барилгын зураг төсөл, төсөв болон Төслийн инженер-геодезийн зургыг боловсруулсан; - УУХҮ-ийн сайдын 2020.03.02-ний өдрийн "Тусгай зөвшөөрөл олгох тухай" А/28 дугаар тушаалаар үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх тусгай зөвшөөрөл авсан; - Төслийн хөрөнгө оруулалт, санхүүгийн нарийвчилсан модель боловсруулж, "Эрдэнэс Монгол" ХХК болон ЗГХЭГ-т хөрөнгө оруулагч талын хувь хэмжээний талаар санал хүргүүлсэн; - Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.7.3-т Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг 2023 онд барьж байгуулахаар тусгасан; - Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 212 тоот тогтоолоор "Эрдэнэс алт ресурс" ХХК-д ашигт малтмал эрэх, хайх эрхийг 4 байршилд олгосон бөгөөд эдгээр хайгуулын тусгай зөвшөөрлийг эргэлтэд оруулах замаар алт цэвэршүүлэх үйлдвэрийн төсөлд шаардлагатай санхүүжилтийн зарим хэсгийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэхээр ажиллаж байна. 	
46.	9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.	2021 - 2028	УУХҮЯ-ны ХҮБГ, Холбогдох яамдууд	424.9	Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ. 0.2%	<p>Зэсийн баяжмал боловруулах үйлдвэрийн хөрөнгө оруулагчийг сонгох аргачлалын төсөл, хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулан Засгийн газарт танилцуулан ЗГ-ын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлийн дагуу ҮАБЗ-д хүргүүлсэн.</p> <p>БОАЖЯ-аас өгсөн зөвлөмжийн дагуу үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэх бэлтгэл ажлын хүрээнд Ажлын баг Өмнөговь аймгийн Ханбогд суманд ажиллаж үйлдвэрийн</p>	30

							<p>ус хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор гадаргын болон газрын доорхи усны эх үүсвэр олох судалгааг гүйцэтгэж, үр дүнгээр тайлан боловсруулсан.</p> <p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн макетыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж. Үйлдвэрийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, гадаад дэд бүтэцтэй холбох судалгааны ажлын хүрээнд үйлдвэр байгуулах талбайн топо суурь зураг, цахилгаан эрчим хүчний агаарын шугам, дэд өртөө, салбар төмөр зам байгуулах замын зураглалыг гүйцэтгэсэн.</p> <p>ЗББҮ-ээс гарах дайвар бүтээгдэхүүн болох хүхрийн хүчлээр фосфорын баяжмалыг боловсруулан фосфорын бордоо үйлдвэрлэх ТЭЗҮ-ийн төсөл боловсруулан УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн БҮСХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.</p> <p>Өмнөговь аймаг, Ханбогд сумын удирдлагуудад төслийн хэрэгжилтийн явц байдал, ач холбогдлыг танилцуулах, хамтран ажиллах талаар санал солилцож ажилласан.</p>	
3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна:	47.	1.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө.	2020 - 2024	УУХҮЯ-ны ГТБГ, АМГТГ, Төрийн байгуулага, Орон нутаг, Хөрөнгө оруулагчид	140,455.7 гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт	Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. ГТ-ны олборлолт 836.4 мян.тн	<p>БХГ-ний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 7 гэрээлэгчтэй жилийн уулзалт хийж, 2020 оны хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг баталсан боловч Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан АМГТГ-аас Гэрээлэгчдийн үйл ажиллагааг түр зогсоох буюу 1 жилийн мораториум олгох шийдвэрийг гаргасан. Харин Номгон IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэж буй Жи Өү Эйч ХХК нь дотоодын нөөц боломжийг ашиглан, 2020 оны 07 дугаар сараас хайгуулын ажлыг эхлүүлж, 1.2 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар хайгуулын 4 цооног өрөмдөж, 105 км чичирхийллийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. 2020 онд нийт 5 БХГ байгуулсан.</p>	70

48.	1.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлно	2020 - 2024	УУХҮЯ-ны ГТБГ, АМГТГ, Гэрээлэгч аж ахуйн нэгжүүд	3,133.9 гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт	Хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна.	БХГ-ний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Гэрээлэгч компаниуд болох Жи Өү Эйч ХХК, Монголын Алт ХХК, Зон Хэн Юу Тиан ХХК, Смарт петролеум ХХК, Түмэн Ойл ХХК, Макс Ойл ХХК-ийн 2020 оны хайгуулын ажлын хөтөлбөр төсвийг хэлэлцэх жилийн уулзалтад санал, зөвлөмж өгч оролцсон. Тус гэрээлэгчид 2020 онд газрын тосны чичирхийллийн судалгаа, цооногийн геофизикийн судалгаа, хайгуулын өрөм, усны цооног өрөмдөх, цооногийн туршилт хийх, нөөцийг тооцоолол хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн, хайгуул, судалгааны ажилд нийт 33.4 сая ам.доллар зарцуулахаар хөтөлбөр, төсвийг баталсан. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас гадаад ажиллах хүч, машин механизм, тоног төхөөрөмж Монгол Улсын хилээр нэвтрэх боломж нөхцөл хязгаарлагдсан, эдийн засгийн байдал хүндэрсэнтэй холбоотойгоор Гэрээлэгчдийн үйл ажиллагааг түр зогсоох буюу 1 жилийн мораториум олгох шийдвэрийг АМГТГ-аас гаргасан.	30
49.	1.3. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	2020 - 2024	УУХҮЯ-ны ГТБГ, АМГТГ, Гэрээлэгч аж ахуйн нэгжүүд	/-/	Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна.	Газрын тосны хайгуулын Богд-4, Онги-5, Т-1 талбайнуудад Петровис ресурс ХХК-тай нүүрсний давхаргын метан хийн хайгуулын БХГ байгуулах асуудлыг Засгийн газрын 2020.02.12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын 57 дугаар тогтоолоор БХГ байгуулах эрх олгосон. Газрын тосны хайгуулын Тавантолгой-33 талбайд Эрдэнэс метан ТӨХХК-тай нүүрсний давхаргын метан хийн хайгуулын БХГ байгуулах асуудлыг Засгийн газрын 2020.04.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын 143 дугаар тогтоолоор БХГ байгуулах эрх олгосон. Засгийн газраас эрх олгосны дагуу Газрын тосны хайгуулын Богд-4, Онги-5, Т-1 талбайнуудад нүүрсний давхаргын метан хийн хайгуулын БХГ-г АМГТГ болон Петровис	90

						ресурс ХХК хооронд 2020.03.25-ны өдөр, Газрын тосны хайгуулын Тавантолгой-33 талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын БХГ-г АМГТГ болон Эрдэнэс метан ТӨХХК хооронд 2020.05.06-ний өдөр тус тус байгуулсан. Мөн Засгийн газрын 2019.12.11-ний өдрийн 435 дугаар тогтоолоор БХГ байгуулах эрх олгосны дагуу газрын тосны хайгуулын Тариач XV талбайд газрын тосны хайгуулын БХГ-г АМГТГ болон Голден Сий ХХК хооронд 2020.10.08-ны өдөр байгуулснаар нийт 5 талбайд БХГ-г шинээр байгуулаад байна.	
50.	1.4. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ-ны ГТБГ, АМГТГ, Гэрээлэгч аж ахуйн нэгжүүд	/-/	Хайгуулын талбайд 1 тогтоосон нөөц байна.	Газрын тосны хайгуулын Матад-XX талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан "Петроматад ХХК-ийн хайгуулын ажлын үр дүнгээр тогтоогдсон газрын тосны нөөцийн тайланг 2020 он 12 дугаар сарын 25-ны өдөр УУХҮЯамны ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж Матад-XX талбайн газрын тосны Баталгаат зэрэглэлийн нөөцийг 1.04 сая баррель, мадагтай зэрэглэлийн нөөцийг 3.45 сая баррель, боломжит зэрэглэлийн нөөцийг 18.27 сая баррелиар тооцоолсныг Эрдэс баялагийн нэгдсэн санд бүртгэж авахаар шийдвэрлэсэн.	70
51.	1.5. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2024	УУХҮЯ-ны ГТБГ, АМГТГ, Гэрээлэгч аж ахуйн нэгжүүд Г	137,321.8 гэрээлэгчдийн хөрөнгө оруулалт	ГТ-ны олборлолт 836.4 мян.тн	Тосон-Уул XIX, Тамсаг XXI орд газарт 2020 онд газрын тосны ашиглалтын 60 цооног өрөмдөх (үүнээс 20 хэвтээ цооног), 2640 метрт перфораци хийх, 150 үед шингэн хагалбар хийх, 80000 тонн тос шавхалтын аргаар олборлох, 81 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, 56 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, 30 цооног их засвар хийх, 85 цооногийг хүчлээр угаах, 16 цооногт полимер шахах, 26 цооногт том хэмжээний шингэн хагалбар хийх, дэд бүтэц, гадаргуун байгууламжийн ажил хийж гүйцэтгэн 382.1 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөсөн боловч дэлхий нийтийг хамарсан	70

						<p>ковид-19 цар тахлын нөлөөгөөр төлөвлөсөн ажлууд хийгдэж чадаагүй болно. Тосон-Уул XIX талбайгаас хоногт дунджаар 319 цооногоор 1235 тонн газрын тос олборлож, 39 автоцистернээр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Бичигт боомтоор, Тамсаг-XXI талбайгаас хоногт дунджаар 306 цооногоор 1204 тонн газрын тос олборлож, 33 автоцистернээр Дорнод аймгийн Халхгол сумын нутагт орших Баянхошуу боомтоор, БХГ-97 талбайгаас олборлосон тосыг төмөр замаар тээвэрлэн Замын-Үүд боомтоор тус тус БНХАУ-д экспортолж байна. Улсын хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 550 мян.тонн газрын тос олборлож, 555 мян.тонн газрын тосыг экспортолж, борлуулалтын орлогоос улсын төсөвт 102,8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Улсын төсвийн орлогын даалгавар, экспортын гүйцэтгэл 93,4%-тай байгаа нь энэ оны эхний хагас жилд цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор экспортын үйл ажиллагааг тодорхой хугацаанд зогсоосон, тээврийн хэрэгслийн тоог хязгаарласан болон дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ огцом буурсантай зэрэг хүчин зүйлтэй холбоотой юм. Гэрээлэгч компаниуд 2020 онд ашиглалт, олборлолтын үйл ажиллагаанд 48.2 сая ам.доллар зарцуулсан.</p>	
52.	2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.	2020 - 2024	Сангийн яам, УУХҮЯ-ны ГТБГ, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	53846.1 БНЭУ-ын хөнгөлөлттэй зээл	Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, Трассын дагуух газрын тусгай хэрэгцээнд авсан	<p>Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн хуралдаанаар Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар танилцуулга хийж 11 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Уг тэмдэглэлийн дагуу \ дамжуулах хоолойн санхүүжилтийн талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаан танилцуулж өгөх хүсэлтийг 2020.02.17-ны өдрийн 01/464 дугаар болон</p>	30

					байна.ТЭЗҮ-ийг хүлээн авсан байна.10%	2020.04.10-ны өдрийн 01/1002 дугаар албан бичгүүдээр Сангийн сайдад хандсан. Газрын тос дамжуулах хоолойг барих төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын урилга, туршлагын талаарх маягтуудад санал авахаар 2020.12.04 өдрийн 01/2971 тоот, төслийн санхүүжилтэд МУ-ын ЗГ-ын баталгаа гаргах нөхцөлтэйгөөр олон улсад сонгон шалгаруулалт явуулах талаар 2020.12.28-ны өдрийн 01/3232 тоотоор тус тус СЯ-нд хандаж саналыг авсан. Мөн төслийн хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах танилцуулгыг 2020.12.09-ний өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулж 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Уг тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг, Сангийн сайдаас ирүүлсэн саналыг тус тус үндэслэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулахаар ажиллаж байна.	
53.	2.3. Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна	2020-2024	УУХҮЯ-ны ГТБГ, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, АМГТГ	/-/	ТЭЗҮ-ийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ТЭЗҮ-ийг хүлээн авсан байна. 10%	Түүхий тос дамжуулах хоолой дамжин өнгөрөх бүс нутгийн эрчим хүч, зам тээврийн дэд бүтцийн өнөөгийн байдал болон хэтийн төлвийг судалж, дамжуулах хоолойн трассыг тэдгээртэй уялдуулж шинэчлэн тогтоох ажлын хүрээнд 2020.08.28-09.06-ны өдрүүдэд Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгуудын нутаг дэвсгэрийг дамжин өнгөрөх трассын дагуу хээрийн судалгааны ажил хийж гүйцэтгэн хоолойн трассыг шинэчлэн тогтоож, 540 км урттай байхаар төлөвлөөд байна. Дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийн ажлын даалгавар боловсруулах, трассыг эцэслэн тогтоох, уг трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар санал, дүгнэлт боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг сайдын 2020.10.23-ны өдрийн А-267 дугаар тушаалаар байгуулж трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авхуулаар холбогдох мэдээллийг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарт хүргүүлээд байна.	30

						Дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барих гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах талаар Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулж байна.	
54.	3.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	2020 - 2024	УУХҮЯ-ны ГТБГ, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК	53846.1 БНЭУ-ын хөнгөлөлттэй зээл	Лицензгүй болон үйлдвэрийн хэрэглээний бус байгууламж, үйлдвэрийн цахилгаан станцын барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн байна. Мөн Лицензит байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. 25%	Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд технологийн зарим байгууламжийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилсан сонгон шалгаруулалт болон гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийг сонгох ажлууд дуусах шатанд байна. Уг ажлуудыг төслийн менежментийн зөвлөх БНЭУ-ын Engineers India Limited компанитай хамтран гүйцэтгэж байгаа ба зөвлөхөөр буюу "Захиалагчийн инженер"-ээр Итали улсын "Prometheus" компани ажиллаж байна. Үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжын ажил /EPC-1/-ыг гүйцэтгэх Энэтхэгийн JMC Projects India компанийг шалгаруулж, 2020.10.13-ны өдөр гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангаж байна. Уг гэрээ байгуулснаар үйлдвэр барих төсөл төлөвлөлтөөс бүтээн байгуулалтын үе шатанд шилжиж байна. Мөн үйлдвэрийн гол дэд бүтэц болох газрын тос дамжуулах хоолой байгуулах төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар болон Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын (EPC) ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн төслийг боловсруулж төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулахаар тендерийн баримт бичгийг	50

						<p>боловсруулан бэлтгэл ажлыг хангаж байна. “Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ы барилга угсралт, үйлдвэрийн хашаа барих ажил, талбай тэгшлэх ажлууд эрчимтэй явагдаж, ашиглалтанд хүлээн авсан үйлдвэрийн гаднах дэд бүтцийн байгууламжуудыг төрийн өмчид бүртгүүлж, ашиглалт, засварын ажлыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэж байна. Ерөнхий сайдын 2020.08.21-ний өдрийн 32-р захирамжаар “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтанд оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих” үүрэг бүхий Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдаж Шадар сайдын 2020.09.01-ний өдрийн 94-р тушаалаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль”-ийн төслийг боловсруулан, Засгийн газрын 2020.12.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 74 дүгээр тэмдэглэл гаргуулан, Ухуулийн төслийг УИХ-д нэн яаралтайгаар өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу 2021.01.13-ны өдрийн 01/77 тоотой хуулийн төслийг УИХ-өргөн мэдүүлэх хүсэлтийг ЗГ-ын ХЭГ-т хүргүүлсэн. EPC-2 Ажлын багцын талаар Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын ажил (EPC-2)-ын хүрээнд Ерөнхий дизайн, инженерчлэлийн багц (Basic design engineering package, BDEP) болон Суурь инженерчлэлийн зураг төсөл (Front End Engineering Design, FEED) нь бэлэн болоод байгаа анхдагч процессийн болон дагалдах байгууламжууд, үйлдвэрийн хангамжийн системийг барьж байгуулах бөгөөд Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн</p>
--	--	--	--	--	--	---

						баримт бичгийг хүлээн авч, санал, техникийн шаардлагуудын хамт төслийн менежментийн зөвлөх компанид хүргүүлэн хэлэлцэж шийдвэрлэсэн. Төслийн менежментийн зөвлөх компанийн боловсруулсан анхдагч процессийн болон дагалдах байгууламжуудын ерөнхий зураг төслийг “Захиалагчийн инженер” Италийн “Prometheus” компанитай хамтран тооцоолон хянаж, сайжруулж болох санал, зөвлөмжүүдийг хүргүүлэн ажилласан. EPC-2 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийг урьдчилан сонгон шалгаруулах тендерийн материалыг хянаж, Энэтхэгийн Эксим банкинд хүргүүлсэн ба тус банкнаас урьдчилсан сонгон шалгаруулалтыг 2020.11.05-ны өдөр зарласан. Одоогоор Larsen & Toubro, Tata Projects, Maire Tecnimont, Afcons зэрэг компаниуд урьдчилсан байдлаар тендерт оролцох сонирхлоо илэрхийлээд байна. EPC-3 Ажлын багцын талаар Үйлдвэрийн 35 МВт хүчин чадалтай 2 ширхэг уурын генератор, 17,5 МВт-ын 2 ширхэг уурын турбин бүхий цахилгаан станцын Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын ажлын (EPC-3) Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн техникийн хэсэг болох 6.600 гаруй хуудас материалыг “Захиалагчийн инженер” Prometheus компанитай хамтран хянаж, шаардлагатай засвар, өөрчлөлтүүдийг хийлгэж эцэслэсэн байна.	
55.	3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулна	2020-2024	УУХҮЯ-ны ГТБГ, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын газрын тос боловсруула	/-/	Хууль батлагдсан байна. 100%	Ерөнхий сайдын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 32-р захирамжаар үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтанд оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан байгуулан ажиллаж байна. Тус	70

			х үйлдвэр ТӨХХК			ажлын хэсгийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 74 дүгээр тэмдэглэл гаргуулсан. Уг тэмдэглэлээр хуулийн төслийг нэн яаралтайгаар Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2021.01.13-ны өдрийн 01/77 тоотор хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх хүсэлтийг ХЭГ-т хүргүүлээд байна.	
56.	3.3. Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ	2020-2024	УУХҮЯ-ны ГТБГ, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд	/-/	Лицензгүй болон үйлдвэрийн хэрэглээний бус байгууламж, үйлдвэрийн цахилгаан станцын барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн байна. Мөн Лицензит байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. 25%	Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн зарим байгууламжийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилсан сонгон шалгаруулах, гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийг сонгох ажлууд дуусах шатанд байна. Үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжын ажил /ЕРС-1/-ыг гүйцэтгэх компанийг шалгаруулж 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр гэрээг байгуулсан. Ерөнхий сайдын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 32-р захирамжаар үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтанд оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан байгуулан ажиллаж байна. Шадар сайдын 2020 оны 94 дүгээр тушаалаар тус ажлын хэсгийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан бөгөөд үүний хүрээнд үйлдвэрт шаардагдах дотоодын түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, барих гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулах талаар Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 69 дүгээр тэмдэглэл гаргуулсан.	30

						Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороог байгуулж байна.	
57.	3.4. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна	2020-2024	УУХҮЯ-ны ГТБГ, АМГТГ, Импортлогч, борлуулагч аж ахуйн нэгжүүд	592000	Шатахууны хангамж тогтвортой байна. 2.1 сая тонн	Засгийн газрын 2019.11.19-ний өдрийн 409 дүгээр тогтоолоор компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилт, компанийн нөөцийн бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавин ажиллаж байна. Компаний нөөц бүрдүүлэх үүрэг бүхий аж ахуйн нэгжүүдийн шатахууны агуулахын үлдэгдэл, нөөцийн мэдээ, тайланг 7 хоног бүрийн Баасан гаригт, шатахууны импорт, борлуулалт, үлдэгдэл, нөөц, үнийн талаарх мэдээ, тайланг 7 хоног бүрийн Мягмар гаригт улсын хэмжээгээр нэгтгэн гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж байна. 2021 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн жагсаалт, бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох мэдээллийг боловсруулан бүх яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2020.09.30-ны өдрийн 01/2400 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2020.10.07-ны өдрийн 136 дугаар тогтоолоор 2021 онд компанийн бүрдүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн жагсаалт, бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг баталсан. АМГТГ уг тогтоолын дагуу компаниудтай гэрээ байгуулж байна.	50
58.	3.5. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна	2020-2024	УУХҮЯ-ны ГТБГ, АМГТГ, Импортлогч, борлуулагч аж ахуйн нэгжүүд	176733	Евро-5 стандартын шатахууны хэрэглээ 15 хувьд хүрсэн байна.	Манай улс газрын тосны бүтээгдэхүүнийхээ хэрэглээг 100% импортоор хангаж байгаа бөгөөд 2020.12.31-ний өдрийн байдлаар 1.851 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэн байна. Үүнээс дизель түлш 966.9 мянган тонн, автобензин 513.1 мянган тонн нийт 1.48 сая тонн шатахуун байгаагаас К5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин, дизель түлш 229.7 мянган тонн буюу нийт шатахууны 15.5	50

						хувийг эзэлж байна. Манай улсын шатахууны гол ханган нийлүүлэгч "Роснефть" ХХК-тай 2020.01.22-24-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо хийсэн уулзалтаар 2020 онд Монгол улсад нийлүүлэх шатахууны төрөл, тоо хэмжээ, үнийн талаар болон Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх талаар санал тавьж хэлэлцсэн. "Роснефть" компанийн хувьд ОХУ-ын дотоодын хэрэгцээг Евро-5 стандартын шатахуунаар хангах асуудал бүрэн шийдэгдээгүй байгаа тул Монгол улсад нийлүүлэх Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх боломжгүй, компаниудын урьдчилсан захиалгын дагуу боломжит хэмжээгээр нийлүүлэх талаар анхаарч ажиллахаа илэрхийлсэн. Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд хэрэглээг дэмжсэн эрхүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох хууль, эрх зүйн орчин бүрдүүлэхтэй холбоотой Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан 2020.09.24-ний өдрийн 01/2345 тоот албан бичгээр БОАЖЯ-нд явуулсан. Автобензин, дизель түлшинд ногдуулах онцгой албан татварыг чанар стандарттай уялдуулан тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх талаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг нэгтгэн боловсруулж, УУХҮСайдын 2020.11.25-ны өдрийн 01/2909 дүгээр албан бичгээр Сангийн яам болон ХЗДХЯ-нд хүргүүлсэн.	
59.	3.6. Баруун бүсийн шатахууны	2020-2024	УУХҮЯ-ны ГТБГ,	175.0	БОНБНҮ-г боловсруулж,	Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах тухай	50

	хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.		Хувийн хэвшил, АМГТГ		батлуулсан байна. 10%	<p>"Трансгэйт интернэшнл" ХХК-ийн 2020.11.11-ний өдрийн 1/171 дугаартай хүсэлтийг судалж сайдын 2020.12.22-ны өдрийн А-327 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилээр сунгасан.</p> <p>Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийгээд байна.</p> <ul style="list-style-type: none"> - Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж аймгийн МХГ, ОБЕГ, барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. - Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийгдсэн. - Геологи инженерийн дүгнэлт гаргуулсан. - Геодезийн дэвсгэр зураг хийлгэсэн. - Цахилгааны зураг төсөл боловсруулсан. Үүнд: Гадна цахилгааны зураг, Дотоод цахилгааны зураг - ОХУ-ын Линас Техно компанитай хамтран ажиллах гэрээ байгуулсан. - ОХУ-ын Кемерово дахь үйлдвэртэй газар дээр нь очиж танилцан, туршлага судалсан. - ОХУ-ын Эрхүү хотын Техникийн Их сургуулийн Нефть боловсруулалтын тэнхимтэй хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан. - Монгол Улсын ШУТИС-ын ГУУС болон ХШУС-тай тус тус хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан. - ШУТИС-ын ХШУС-тай хамтран, газрын тос боловсруулах технологийн дүрмийг хөрвүүлэн, технологийг нутагшуулах чиглэлээр ажиллаж байна. 	
60.	3.7. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин	2020-2024	УУХҮЯ-ны ГТБГ, АМГТГ, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам		Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин	Газрын тосны тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулах, хуулийн төслийг боловсруулах, дагалдах бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулаад байна.	30

		бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна				бүрдүүлэх хүрээнд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, УИХ-д хүргүүлэх 10%.		
3.5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана.	61.	1. Монгол улсын газар нутгаар дайруулан татах хийн хоолойн судалгааг хийнэ.	2021 - 2024	Эрдэнэс Монгол ХХК, УУХҮЯ-ны ГТБГ, Эрчим хүчний яам		Судалгааны ажил эхэлсэн байна	Ерөнхий сайдын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 03 тоот захирамжаар Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн бэлтгэл ажлыг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Уг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна.	30
	62.	2. ОХУ, БНХАУ-ыг холбосон хийн хоолой Монгол Улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх трассын хувилбарыг боловсруулж, төслийн нэгжийг мэдээллээр хангана.	2020 - 2021	Шадар сайдын ажлын алба, УУХҮЯ-ны ГТБГ, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, Бусад холбогдох байгууллагууд		Хийн хоолой дайран өнгөрөх трассын хувилбарыг боловсруулсан байна.	Монгол Улсын Шадар сайдаас 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн ЗГ-2/58 тоот албан бичгээр ирүүлсэн Оросын Холбооны Улс, БНХАУ-ыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн бэлтгэл ажлыг хангах асуудлын хүрээнд зарим аймаг, сумдын нутаг дэвсгэрийг хамарсан байр зүйн зургийг бэлтгэн холбогдох материалын хамт 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 03/646, 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/2497 тоот албан бичгээр тус тус хүргүүлж мэдээллээр хангаж ажилласан.	30
3.6.3. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд	63.	2.1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн	2021 - 2024	ЗТХЯ, УУХҮЯ-ны ГТБГ, Төрийн		Цахилгаанаар цэнэглэх 12 цэг, хийгээр цэнэглэх 6 станц	Үндсэн хэрэгжүүлэгч яам болон холбогдох бусад байгууллагаас арга хэмжээг хэрэгжүүлэх талаар асуудал тавиагүй байна.	0

нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ:		хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.		худалдан авах ажиллагааны газар, Хувийн хэвшил, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар				
3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.	64.	1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ.	2020 - 2024	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, БХБЯ, УУХҮЯ, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн банк, холбогдох байгууллагууд	132470.6	Барилга ажлыг бүрэн дуусгаж, тоног төхөөрөмж суурилуулсан байна.	Төслийн хүрээнд үйлдвэрийн барилгын ажил бүрэн дууссан. Үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна. Домен зуух №1 100%, домен зуух №2 60%, кран, өргөх байгууламж 100%, хүчилтөрөгчийн конвертор 100%, цахилгаан нуман зуух 90%, шанаган зуух 100%, тасралтгүй цутгах машин 85%, хөргөлтийн усан сан 100%, хүчилтөрөгчийн станц 100%, цувих 60%. цахилгаан дэд станц хангамж 80% ус хангамж 100%-д хүрсэн. Үйлдвэр ашиглалтад оруулах хугацаатай уялдуулан үйлдвэрийн шугамуудыг үе шаттайгаар ашиглалтад оруулна.	70
	65.	2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.	2020 - 2024	БХБЯ, УУХҮЯ, НЗДТГ, Хөгжлийн банк, холбогдох байгууллагууд		Шилний үйлдвэр барих төсөл боловсруулж холбогдох газарт хүргүүлнэ	Тусгай зөвшөөрлийг БХБЯ-аас олгож байгаа тул тус яамнаас биелэлт гарах боломжгүй. Үндсэн хэрэгжүүлэгч яам болон холбогдох бусад байгууллагаас арга хэмжээг хэрэгжүүлэх талаар асуудал тавиагүй байна.	0
	66.	3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг	2020 - 2024	БХБЯ, УУХҮЯ, Ховд аймгийн засаг даргын		Цементийн үйлдвэрийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ	Ховд эко цементийн үйлдвэрийн төслийг “Вестерн холд” ХХК хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү үйлдвэр ашиглалтанд орсноор баруун бүсийн цементийн хэрэглээг бүрэн хангах юм.	50

	ашиглалтад оруулна.		тамгын газар, Хөгжлийн банк, Бусад холбогдох байгууллагууд			Цар тахалтай холбоотойгоор төслийн ажлын явц тодорхой хугацаагаар хойшилсон ч төслийг 2021 оны IV улиралд багтаан ашиглалтад оруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар төслийн явц 50%-тай байна. Үүнд: 1.Металл хийц үйлдвэрлэлт- 100% 2.Металл хийц угсралт-0% 3.Тоног төхөөрөмж үйлдвэрлэл- 100% 4.Тоног төхөөрөмж нийлүүлэлт- 50% 5.Тоног төхөөрөмж угсралт- 0% 6.Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэлт-100% 7.Цахилгаан тоног төхөөрөмж угсралт -0% 8.Бетон цутгалт- 49%	
67.	4. Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.	2021 - 2024	УУХҮЯ, БХБЯ, Хувийн хэвшил	Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн хэрэгжилтийн байдалд судалгаа хийнэ	Барилгын материалын түүхий эдийн судалгаа хийхэд эрх зүйн тусгайлсан хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодруулах зорилгоор Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн бусад холбогдох хуулиудтай зөрчил, давхардал, хийдэл байгаа эсэхийг тогтоож, тодруулах судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан. Энэхүү судалгааны үр дүнд Түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой харилцааг зохицуулах тусгайлсан хууль шаардлагагүй гэдэгт тогтоогдсон байна. Иймд энэхүү асуудлыг тусган Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Улмаар УИХ-д өргөн мэдүүлсэн боловч байнгын хороодоор хэлэлцэх явцад хуулийн төслийг дахин боловсруулахаар буцаасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон. Эдгээр чиглэл болон эрх зүйн өөрчлөлтүүдтэй уялдуулан Хуулийн төслийг дахин боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын	30	

							2020 оны А/332 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоол гарсан.	
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	68.	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж	2021-2024	УУХҮЯ-ны ТЗУГ, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Харьяа байгууллагууд	Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ.	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна. 2021 оны Сургалтын төлөвлөгөөндөө ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	90	
4.3.17. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал,	69.	1. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.	2020-2022	УУХҮЯ-ны ГТБГ, УУБГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар	Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.	Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан "Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-д 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан.	70	

хяналтыг сайжруулна.							Мөн Улсын онцгой комиссын 2020 оны 35 дугаар тэмдэглэлийн 3.6-д “уул уурхайн зориулалттай сэлбэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, бараа материалын тээвэрлэлт, түгээлтийг халвдвар хамгаалалын дэглэмийг сайтар мөрдөж, ариутгал, халдваргүйжүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу аймйг, нийслэл, орон нутагт саадгүй нэвтрүүлэх” заалтыг тусгуулж шийдвэрлүүлсэн.	
4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.	70.	4. БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021-2024	УУХҮЯ-ны ГТБГ, Сангийн яам, Гадаад харилцааны яам	Үйлдвэрийг барьж байгуулахаар хэрэгжүүлж буй төсөлд тодорхой ахиц гарсан байна.	Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд технологийн зарим байгууламжийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийн урьдчилсан сонгон шалгаруулалт болон гүн боловсруулалтын технологийн лиценз эзэмшигчдийг сонгох ажлууд дуусах шатанд байна. Уг ажлуудыг төслийн менежментийн зөвлөх БНЭУ-ын Engineers India Limited компанитай хамтран гүйцэтгэж байгаа ба зөвлөхөөр буюу “Захиалагчийн инженер”-ээр Итали улсын “Prometheus” компани ажиллаж байна. Үйлдвэрийн технологийн бус барилга байгууламжын ажил /EPC-1/-ыг гүйцэтгэх Энэтхэгийн JMC Projects India компанийг шалгаруулж, 2020.10.13-ны өдөр гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангаж байна. Уг гэрээ байгуулснаар үйлдвэр барих төсөл төлөвлөлтөөс бүтээн байгуулалтын үе шатанд шилжиж байна. Мөн үйлдвэрийн гол дэд бүтэц болох газрын тос дамжуулах хоолой байгуулах төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар болон Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын (EPC) ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн төслийг боловсруулж төслийг санхүүжүүлэх, барьж байгуулах гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтаар	50	

							<p>шалгаруулахаар тендерийн баримт бичгийг боловсруулан бэлтгэл ажлыг хангаж байна. “Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ы барилга угсралт, үйлдвэрийн хашаа барих ажил, талбай тэгшлэх ажлууд эрчимтэй явагдаж, ашиглалтанд хүлээн авсан үйлдвэрийн гаднах дэд бүтцийн байгууламжуудыг төрийн өмчид бүртгүүлж, ашиглалт, засварын ажлыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэж байна. Ерөнхий сайдын 2020.08.21-ний өдрийн 32-р захирамжаар “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтанд оруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих” үүрэг бүхий Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдаж Шадар сайдын 2020.09.01-ний өдрийн 94-р тушаалаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль”-ийн төслийг боловсруулан, Засгийн газрын 2020.12.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 74 дүгээр тэмдэглэл гаргуулан, Ухуулийн төслийг УИХ-д нэн яаралтайгаар өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу 2021.01.13-ны өдрийн 01/77 тоотоор хуулийн төслийг УИХ-өргөн мэдүүлэх хүсэлтийг ЗГ-ын ХЭГ-т хүргүүлсэн. ЕРС-2 Ажлын багцын талаар Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын ажил (ЕРС-2)-ын хүрээнд Ерөнхий дизайн, инженерчлэлийн багц (Basic design engineering package, BDEP) болон Суурь инженерчлэлийн зураг төсөл (Front End Engineering Design, FEED) нь бэлэн болоод байгаа анхдагч процессийн болон дагалдах байгууламжууд, үйлдвэрийн хангамжийн системийг барьж байгуулах бөгөөд Ерөнхий</p>
--	--	--	--	--	--	--	---

							гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг хүлээн авч, санал, техникийн шаардлагуудын хамт төслийн менежментийн зөвлөх компанид хүргүүлэн хэлэлцэж шийдвэрлэсэн. Төслийн менежментийн зөвлөх компанийн боловсруулсан анхдагч процессийн болон дагалдах байгууламжуудын ерөнхий зураг төслийг "Захиалагчийн инженер" Италийн "Prometheus" компанитай хамтран тооцоолон хянаж, сайжруулж болох санал, зөвлөмжүүдийг хүргүүлэн ажилласан. ЕРС-2 багц ажлын Ерөнхий гүйцэтгэгчийг урьдчилан сонгон шалгаруулах тендерийн материалыг хянаж, Энэтхэгийн Эксим банкинд хүргүүлсэн ба тус банкнаас урьдчилсан сонгон шалгаруулалтыг 2020.11.05-ны өдөр зарласан. Одоогоор Larsen & Toubro, Tata Projects, Maire Tecnimont, Afcons зэрэг компаниуд урьдчилсан байдлаар тендерт оролцох сонирхлоо илэрхийлээд байна. ЕРС-3 Ажлын багцын талаар Үйлдвэрийн 35 МВт хүчин чадалтай 2 ширхэг уурын генератор, 17,5 МВт-ын 2 ширхэг уурын турбин бүхий цахилгаан станцын Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын ажлын (ЕРС-3) Ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн техникийн хэсэг болох 6.600 гаруй хуудас материалыг "Захиалагчийн инженер" Prometheus компанитай хамтран хянаж, шаардлагатай засвар, өөрчлөлтүүдийг хийлгэж эцэслэсэн байна.	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га	71.	1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2020-2024	УУХҮЯ-ны УУБГ, Аймаг, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал	84 сая төг Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дах хэсэгт "Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны	90

талбайг нөхөн сэргээнэ.				жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар			төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ” гэж заасны дагуу уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд нийт 17 тэрбум төгрөгийг байршуулсан байна. 2020 онд “Эм жи эйч” ХХК-ийн Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт эзэмшиж байгаад цуцлагдсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон 40.65 га талбайгаас 10 га талбайд хийх техникийн нөхөн сэргээлтийг тус компанийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн сангийн Байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд байршуулсан нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөөр гүйцэтгэсэн байна. Мөн Улсын хэмжээнд 2019 онд уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас нийт 7078.9 га талбай уулын ажилд хамрагдсанаас техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай нь 1927.6 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 704.8 га, нөхөн сэргээлтэнд зарцуулсан зардал 28.7 тэрбум төгрөг, байгаль орчинг хамгаалахад зарцуулсан зардал 15.8 тэрбум төгрөг байна.	
5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон	72.	2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн	2020-2024	БОАЖЯ, ЭХЯ, ЗТХЯ, СЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ Онцгой байдлын	Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан ногоон санхүүжилтийн бүтцэд	Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр, зорилт арга хэмжээг тодорхойлох баримт бичгийг боловсруулах үүрэг бүхий Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт тус яамнаас холбогдох албан тушаалтнууд ажилласан болно.	30	

<p>хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.</p>		<p>хэрэгжилтийг хангана.</p>		<p>ерөнхий газар, Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Үндэсний хөгжлийн газар, Олон улсын байгууллага</p>		<p>Засгийн газар хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсон байна.</p>	<p>Ажлын хэсгээс Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд өчүүхэн (0.09%) хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их байгааг тогтоосон. Мөн 2014 онд нийт 34482.73 мян.тн CO² ялгаруулсны 50.08% нь эрчим хүч, 48.51% нь хөдөө аж ахуй, 0.95% нь аж үйлдвэр, үлдсэн 0.46 нь хог хаягдлын салбараас ялгарсан байна. Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгаралд 2020 онд нүүрсий олборлолт 4.9%,-ийг эзэлж байна.</p> <p>Дээр дурдсан баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээнд нүүрсний уурхайн метан хийг ашиглах асуудлыг 2025-2030 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан болно.</p> <p>Газрын тосны хайгуулын Богд-4, Онги-5, Т-1 талбайнуудад Петровис ресурс ХХК-тай нүүрсний давхаргын метан хийн хайгуулын БХГ байгуулах асуудлыг Засгийн газрын 2020.02.12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын 57 дугаар тогтоолоор БХГ байгуулах эрх олгосон. Газрын тосны хайгуулын Тавантолгой-33 талбайд Эрдэнэс метан ТӨХХК-тай нүүрсний давхаргын метан хийн хайгуулын БХГ байгуулах асуудлыг Засгийн газрын 2020.04.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын 143 дугаар тогтоолоор БХГ байгуулах эрх олгосон. Засгийн газраас эрх олгосны дагуу Газрын тосны хайгуулын Богд-4, Онги-5, Т-1 талбайнуудад нүүрсний давхаргын метан хийн хайгуулын БХГ-г АМГТГ болон Петровис ресурс ХХК хооронд 2020.03.25-ны өдөр, Газрын тосны хайгуулын Тавантолгой-33 талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын БХГ-г АМГТГ болон Эрдэнэс метан ТӨХХК хооронд 2020.05.06-ний өдөр тус тус байгуулсан. Манай улс газрын тосны бүтээгдэхүүнийхээ хэрэглээг 100% импортоор</p>
--	--	------------------------------	--	--	--	---	--


						<p>хангаж байгаа бөгөөд 2020.12.31-ний өдрийн байдлаар 1.945 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэн байна. Үүнээс дизель түлш 1.026 сая тонн, автобензин 584.8 мянган тонн нийт 1.612 сая тонн шатахуун байгаагаас K5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин, дизель түлш 253.3 мянган тонн буюу нийт шатахууны 15.7 хувийг эзэлж байна. Манай улсын шатахууны гол ханган нийлүүлэгч "Роснефть" ХХК-тай 2020.01.22-24-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо хийсэн уулзалтаар 2020 онд Монгол улсад нийлүүлэх шатахууны төрөл, тоо хэмжээ, үнийн талаар болон Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх талаар санал тавьж хэлэлцсэн. "Роснефть" компанийн хувьд ОХУ-ын дотоодын хэрэгцээг Евро-5 стандартын шатахуунаар хангах асуудал бүрэн шийдэгдээгүй байгаа тул Монгол улсад нийлүүлэх Евро-5 стандартын шатахууны хэмжээг нэмэгдүүлэх боломжгүй, компаниудын урьдчилсан захиалгын дагуу боломжит хэмжээгээр нийлүүлэх талаар анхаарч ажиллахаа илэрхийлсэн. Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэхийг дэмжих, экологийн бага ангиллын шатахууны хэрэглээг үе шаттай хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр автобензин, дизель түлшинд ногдуулах онцгой албан татварыг чанар стандарттай уялдуулан тогтоох, зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах талаар Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг нэгтгэн боловсруулж, УУХҮ-ийн сайдын 2020.11.25-ны өдрийн 01/2909 дүгээр албан бичгээр Сангийн яам болон ХЗДХЯ-нд, агаарын чанарыг сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахуун</p>
--	--	--	--	--	--	---

							жиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох талаар Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан 2020.09.24-ний өдрийн 01/2345 тоот албан бичгээр БОАЖЯ-нд тус тус хүргүүлсэн. Номгон IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэж буй Жи Өү Эйч ХХК нь дотоод нөөц боломжийг ашиглан, 2020.07-р сараас хайгуулын ажлыг эхлүүлсэн ба нийт 4 цооног өрөмдөж, 105 км чичирхийллийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.	
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН								50.3

ХЯНАСАН: ХШУДАГ-ын дарга

 Ц.Одхүү

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН: ХШУДАГ-ын ахлах шинжээч

 Х.Цэнд-Аюуш